



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/166

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, мөн зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, мөн хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, мөн хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын 2019 онд өөрийн хөрөнгөөр санхүүжих тоног төхөөрөмж, программ хангамж худалдан авах ажлыг зохион байгуулах, гүйцэтгэгчийг нээлттэй шалгаруулалтын журмаар сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Эрх зүй, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн С.Цоггэрэл

Нарийн бичгийн дарга: Мэргэжилтэн Г.Ууганцэцэг

Гишүүд: Хууль зүй дотоод хэргийн яамны, Санхүү хөрөнгө

оруулалтынхэлтсийн мэргэжилтэн Г.Базаргүр

Барааны тэмдгийн шинжээч Б.Оюунцэцэн

Худалдан авах ажиллааганы хөтөч багш Н.Батболд

2.Тендер сонгон шалгаруулах ажлыг хуулийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга С.Цоггэрэлд даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавих ажиллахыг Хяналтын хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.ГАНЗОРИГ

000538